



**ХӨВСГӨЛ АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН ТАМГЫН ГАЗАР  
САНХҮҮ ТӨРИЙН САНГИЙН ХЭЛТЭС**

**2017 ОНЫ ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛИЙН ӨНӨӨГИЙН  
БАЙДЛЫН ТАНИЛЦУУЛГА**

**/ 2017 оны 09 сарын 30-ны байдлаар /**

## 2017 ОНЫ ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛИЙН ӨНӨӨГИЙН БАЙДАЛ

### Орон нутгийн орлогын талаар:

2017 онд аймгийн төсөвт **91 тэрбум 380.2** сая төгрөг орохоор төлөвлөснөөс, 74 тэрбум 466.4 сая төгрөг буюу 81,4 хувийг санхүүжилтийн орлого, 10 тэрбум 734.0 сая төгрөг буюу 11,7 хувийг татварын болон татварын бус орлого эзэлж байна.

Эхний 9 сарын байдлаар орон нутгийн орлого 7 тэрбум 698.4 сая төгрөгийн төлөвлөгөөтэйгээс 8 тэрбум 887.0 сая төгрөг буюу 115 хувийн гүйцэтгэлтэй гарсан.

Үүнд: татварын орлого 116% давж биелсэн бол, татварын бус орлого 107%-иар биелжээ. Жилийн батлагдсан төлөвлөгөөнөөс тооцвол орон нутгийн орлогын гүйцэтгэлийн хувь 83 хувийн биелэлттэй байна.

Эхний 9 сарын байдлаар аймагт олгогдох тусламжийн орлогоос санхүү дэмжлэг, тусгай зориулалтын шилжүүлгийн орлого төлөвлөгөөний дагуу 100 % санхүүжсэн бол харин орон нутгийн хөгжлийн нэгдсэн сангаас шилжүүлэх орлого төлөвлөгөө 1 тэрбум 687,1 сая төгрөг байхаас шилжүүлгээр 1 тэрбум 546,9 сая төгрөг буюу **-140,2** сая төгрөгөөр тасарсан, биелэлт 91,7 хувьтай байна.

Орон нутгийн татварын орлогын биелэлт 9 дүгээр сарын гүйцэтгэлийн байдлаар **115,9** хувиар, жилийн батлагдсан дүнгээс тооцвол **82,7** хувийн биелэлттэй байна. Татварын орлогыг нэр төрөл бүрээр авч үзвэл: орлогын албан татвар 73,1, хөрөнгийн албан татвар 101,2, бусад татвар төлбөр хураамж 93,4, бусад нийтлэг татвар хураамж 83,3, газрын төлбөр 80,9, байгалийн нөөц ашигласны төлбөр 97, бусад татвар 22,9 нийтлэг татварын бус орлого 82,4, хөрөнгийн орлого 252,1 хувийн гүйцэтгэлтэй байна.

Орон нутгийн орлого давалтанд голлон нөлөөлсөн орлогууд нь цалин хөдөлмөрийн хөлс, шагналын орлого жилийн батлагдсан дүнгээс 104.5, шууд бус орлого 213.3, ойн нөөц ашигласны төлбөр 111.3, ан амьтны нөөц ашигласны төлбөр 330 хувийн биелэлттэй байна.

Орон нутгийн орлого тасарсан орлогууд нь бууны татвар 51.6, түгээмэл тархацтай ашигт малтмал ашигласны төлбөр 40, хувьцааны ноогдол ашиг 61,9 хувийн гүйцэтгэлтэй байна.

2017 оны 3 дугаар улирлын байдлаар жилийн батлагдсан төлөвлөгөө гүйцэтгэлийн хувиар 100 хувиас давж биелсэн 10 сум, 90-99 хувийн биелэлттэй 5 сум, 80-89 хувийн биелэлттэй 2 сум, 70-79 хувийн биелэлттэй 4 сум, 60-69 хувийн биелэлттэй 2 сум, 50-59 хувийн биелэлттэй 1 сум байна.

### **Зарлагын талаар:**

2017 оны нийт зарлагын төлөвлөгөө 91тэрбум 380.2 сая төгрөг, үүнээс 9 дүгээр сарын 30-ны байдлаар гүйцэтгэл 60тэрбум 905.3 сая төгрөг буюу 91,8 хувийн гүйцэтгэлтэй, жилийн төлөвлөгөөнөөс тооцход 66,7 хувийн гүйцэтгэлтэй байна. 9 дүгээр сарын байдлаар үлдэгдэл төсөв нь 5тэрбум 455.4 сая төгрөг байна.

Нөлөөлсөн гол хүчин зүйл нь:

1. Хөрөнгийн зардлын гүйцэтгэл 45,7 хувьтай
2. Сум хөгжүүлэх сангийн зээл олголт 25,2 хувьтай

Хөрөнгө оруулалтын гүйцэтгэлийг авч үзэхэд Орон нутгийн хөрөнгө оруулалтын гүйцэтгэл 38,2 хувь, Орон нутгийн хөгжлийн сан 54,3 хувь, Замын сангийн хөрөнгө 13,7 хувийн гүйцэтгэлтэй байна.

Сум хөгжүүлэх сангийн зээлийн эргэн төлөлт 27,5 хувийн гүйцэтгэлтэй байгаагаас шалтгаалсан иргэд, аж ахуйн нэгжүүдэд олгох зээлийн эх үүсвэрийн дутагдлаас шалтгаалан 25,2 хувийн гүйцэтгэлтэй гарчээ.

### **Өр, авлагын талаар:**

Аймгийн ТЕЗ-ийн багцын нийт өглөг 2016 оны мөн үед 964,6 сая төгрөг байсан бол 2017 оны 9 дүгээр сарын 30-ний байдлаар 535,0 сая төгрөг буюу 429,4 сая төгрөгөөр буурсан боловч Ханх 11,1 , Бүрэнтогтох 8,3 , Цагаан-үүр 48,3 сая төгрөгөөр тус тус өмнөх оны мөн үеэс нэмэгдсэн байна.

Аймгийн ТЕЗ-ийн багцын нийт авлага 2017 оны 3 дугаар улирлын байдлаар 228,7 сая төгрөг гарсан нь өмнөх оны мөн үеэс 82,1 сая төгрөгөөр нэмэгдсэн байна. Авлага нэмэгдсэн шалтгаан нь Бүрэнтогтох 36,1, Тосонцэнгэл 47,9 , Ханх 8,1, Цэцэрлэг 7,4, Шинэ-идэр 15,5, Цагааннуур сум 5,2 сая төгрөгөөр тус тус нэмэгдсэнтэй холбоотой.

Эдгээрээс гадна сумдтай холбоотой Тариалан эрхлэлтийг дэмжих сангаас 4 жилийн хугацаатай авсан бага оврын тракторын зээлийн өр 760,9 сая төгрөг, улсын нөөцөд төлөх өвс тэжээлийн өр 22,3 сая төгрөг, аймгийн мал хамгаалах санд төлөх 136,5 сая төгрөгийн өр төлбөр байна.